

**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ****Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага****1.1.Хууль зүйн үндэслэл:**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050”<sup>1</sup> Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 7.4.1-д “Салбарын эрх зүйн шинэтгэлийг нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн төгөлдөржүүлнэ”, 7.4.4-д “Салбарын алба хаагчдын цалин, хөлсний нэмэгдлийг тухайн жилийн инфляцын өсөлт, өндөр хөгжилтэй орны ижил төрлийн байгууллагын түвшинд хүргэнэ”, 7.4.13-т “... орон нутаг дахь шүүхийн шинжилгээний албаны ажиллах орчныг сайжруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д “Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулах” гэж тус тус тусгасан.

**1.2.Практик шаардлага:**

Шүүх шинжилгээний байгууллагын алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний ажилдаа хандах хандлага, итгэл үнэмшил, хариуцлагыг нэмэгдүүлэх, ажлын бүтээмж, үр дүнг сайжруулах хуульд заасан баталгаагаар тэгш хангах зорилгоор “Шүүх шинжилгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгыг Монгол Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 14 бүлгийн 85 гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох асуудлыг Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт “... гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргана” гэж хуульчилсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2023 оны А/268, А/275 дугаар хамтарсан тушаалаар “Гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах журам”-ыг батлуулж, хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус газар нь гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээний 389 тогтоол, шийдвэр 2023 онд ирснээс 143

---

<sup>1</sup> Монгол Улсын Их Хурлын 2020 оны 54 дүгээр тогтоолын хавсралт, Төрийн мэдээлэл эмхэтгэл 2020 оны №25,

шинжилгээг хийж, дүгнэлт гаргасан. 2024 онд 975 шинжилгээ хийлгэх тогтоол шийдвэр ирснээс 562 шинжилгээ хийж, дүгнэлт гаргаад байна.

Үүнээс үзэхэд шинжилгээний тоо цаашид нэмэгдэх үзүүлэлттэй байгаа бөгөөд шинжилгээ хийхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага үүсээд байна.

Монгол Улсын хэмжээнд нохойд хазуулсан шалтгаанаар осол, гэмтэлд өртөж, эмнэлгийн байгууллагад хандсан 2023 онд 3749 хүн хандсан бөгөөд үүнээс 0-18 насны 1723 хүүхэд, 2024 оны эхний 8 сарын байдлаар 2467 хандсан бөгөөд 0-18 насны 1195 хүүхэд тус тус хандаж эмчилгээ, үйлчилгээ авчээ.

Дээрх хохирсон иргэдийн дийлэнх хувь нь бага насны хүүхэд байгаатай холбогдуулан эцэг эх, асран хамгаалагч хүүхдэдээ сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээ хийлгэх хүсэлтийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий цагдаагийн байгууллагад гаргадаг боловч Шүүх шинжилгээний тухай хуульд гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож болох гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20 дугаар бүлгийн 20.15 дугаар зүйлд заасан “Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах” гэмт хэрэг тусгагдаагүй учир тухай бүрд хүсэлтийг шийдвэрлэж чадаагүй буцаасан талаар цагдаагийн байгууллагаас мэдэгдсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно” гэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтад “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд оршино” гэж тус тус заасан боловч дээрх иргэдийн хууль зүйн туслалцаа авах, хохирлоо нөхөн төлүүлэх Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдэлж чадахгүй байх нөхцөл байдал үүсээд байна.

Шүүх шинжилгээний тухай хуульд сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргуулахаар заасан гэмт хэргүүдийг тогтоохдоо гэмт хэргийн улмаас хувь хүн хохирсон байх гэсэн шаардлагыг харгалзан сонгосон боловч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20 дугаар бүлгийн 20.15 дугаар зүйлд заасан “Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах”, 28 дугаар бүлгийн 28.9 дүгээр зүйлд заасан “Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих” гэмт хэргүүдийг тусгаагүй байх тул хуульд нэмж оруулах шаардлагатай байна.

Шүүх шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулахаар заасан.

Тус хуулийн 11.4 дэх хэсэгт шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах Монгол Улсын иргэнд тавигдах шаардлагыг тодорхойлсон бөгөөд 11.4.2-т “шүүх шинжилгээний сургалтад хамрагдсан байх” гэж заасан боловч энэхүү сургалтын төрөл, зохион байгуулалт, төлбөрийн хэмжээг тогтоосон харилцааг зохицуулах захиргааны хэм хэмжээний актыг хэрхэн батлах тухай заалтыг хуульд заагаагүй байна. Түүнчлэн Зөвшөөрлийн тухай хуульд заасан мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай, энгийн зөвшөөрөл эзэмшигч (нотариатын, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх, хуульчийн, сувилах, эм барих, эмчлэх, эх барих мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх)-ийн нэг жилд хангах багц цаг<sup>2</sup>ийн хэмжээг тогтоож, зөвшөөрөл олгосон байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран, сургалтыг зохион байгуулдаг бөгөөд шүүх шинжилгээний арга аргачлал, эрх зүйн зохицуулалтууд тодорхой цаг хугацаанд өөрчлөгдөж байдаг тул шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигчид давтан сургалтыг зохион байгуулах эрх зүйн зохицуулалт зэргийг Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлтээр оруулах шаардлагатай байна.

Тухайлбал, Галт зэвсгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт “иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтыг цагдаагийн байгууллага зохион байгуулж, сургалтын зааврыг цагдаагийн төв байгууллагын дарга батална” гэж; Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “Харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх асуудлыг цагдаагийн төв байгууллага хариуцна” гэж; Цагдаагийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 17.1-д заасан төв нь албаны нохой ашиглах болон Галт зэвсгийн тухай хуулийн 10.4-т заасан болон гэрээт харуул хамгаалалтын сургалтыг төлбөртэй зохион байгуулж болно”; мөн зүйлийн 17.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 17.3-т заасан сургалтын төлбөрийн хэмжээг дотоод хэргийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно” гэж тус тус хуульчлан заасан байна.

Шүүх шинжилгээний тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2 дахь хэсэгт “Аймаг, сумын нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа алба хаагчид 5 жил тутамд нэг удаа 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас олгоно”, мөн 80 дугаар зүйлийн 80.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 71.2-т заасан 5 жил тутамд олгох мөнгөн тэтгэмжийг энэ хууль батлагдсан өдрөөс хойш тооцно” гэж заасан.

Тус байгууллагын аймаг, орон нутагт таваас дээш жил ажиллаж байгаа нийт 110 алба хаагч “..... Цагдаагийн албаны тухай хууль 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, орон нутагт таван жил ажилласан алба хаагчдад 30 сарын үндсэн цалинтай тэнцэх тэтгэмжийг 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн бол Гамшгийн тухай хууль 2022 онд, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2021 онд батлагдсан бөгөөд Онцгой байдлын байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагууд дээрх тэтгэмжийг 2023 онд олгохоор төлөвлөсөн байна. Шүүх шинжилгээний тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.3 дахь хэсэгт “энэ хуулийн

---

<sup>2</sup> Боловсролын ерөнхий хуулийн 3.1.4.“багц цаг” гэж боловсролын агуулгын багтаамжийг хэмжих нэгжийг;

71.2-т заасан мөнгөн тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална” гэж зохицуулж өгсөн байх тул журмын төсөлд шууд олгуулах асуудлыг тусгаж өгнө үү.” гэсэн утга бүхий хүсэлт гаргасан.

Аймаг, орон нутагт ажиллаж байгаа алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх, шинжээчдийн ажлын ачааллыг харгалзан шаардлагатай санхүүжилтийг 2024 оны төсвийн төсөлд тусган танилцуулж, дэмжигдсэн.

Иймд дээрх хууль зүйн болон практик үндэслэл, шаардлагад үндэслэн Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлсон болно.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу боловсруулав.

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгана.

-Шүүх шинжилгээний тухай хуулийн 40 дүгээр зүйлд Эрүүгийн хуулийн 20.15 дугаар зүйл. /Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах/, 28.9 дүгээр зүйл. /Байлдааны зэвсэг, галт хэрэгсэл, орчиндоо аюул учруулж болох бусад хэрэгсэлтэй харьцах журам зөрчих/” гэмт хэргийг нэмэлтээр тусгах.

-Шүүх шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.2-т заасан Шүүх шинжилгээний сургалтын төрөл, зохион байгуулалт, төлбөрийн хэмжээг тогтоосон харилцааг зохицуулсан заалтыг тусгах.

-Аймаг, орон нутагт ажиллаж байгаа алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх зорилгоор Шүүх шинжилгээний тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.3 дахь хэсэгт заасан шилжилтийн үеийн зохицуулалтыг хүчингүй болгох.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгмийн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар:**

Хуулийн төсөл батлагдсанаар хуулийн хэрэгжилт, ур нөлөө сайжирч, дараах эерэг үр дүн гарна гэж тооцоолж байна.

Эрүүгийн хуулийн 20.15 дугаар зүйл, мөн хуулийн 28.9 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах боломжийг бүрдүүлснээр хүний эрх, эрх чөлөөг хангах, хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх ач холбогдолтой.

Шүүх шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн иргэд болон шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигчид мэргэжлийн болон давтан сургалтыг зохион байгуулснаар шинжилгээг шинжлэх ухааны үндэслэл бүхий арга аргачлал, шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартыг баримтлан, тал бүрээс нь бүрэн бодитой хийх хуульд заасан шаардлагыг хангана;

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д “Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулах” зорилтыг хангаж, аймаг, орон нутагт ажиллаж байгаа алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх боломж бүрдэнэ;

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх, холбогдох хууль тогтоомжтой уялдсан байдал, хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомжийн төслийн талаар:**

Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулсан бөгөөд хуулийн төслийг дагалдан гарах хууль тогтоомж байхгүй болно.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_